

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **“Босоо насос 2 нэр төрөл / босоо насос бүтээмж 400м.куб, түрэлт 105м.у.б/ “Грундфос” ба түүнтэй дүйцэхүйц ”** нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/201901082**

“Монголросцветмет” ТӨҮГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **” Босоо насос 2 нэр төрөл / босоо насос бүтээмж 400м.куб, түрэлт 105м.у.б/ “Грундфос” ба түүнтэй дүйцэхүйц ”** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг **2019 оны 09 дүгээр сарын 03-ны 09:00 цаг**-аас өмнө **Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn** хаягаар ирүүлнэ.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000.00 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 09 дүгээр сарын 03-ны** өдрийн **09:05** цагт цахимаар нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98,
“Монголросцветмет” ТӨҮГ-ын офисын байрын 4 давхарт
409 тоот өрөө, Утас: 11-450060 -188**